


“Жэтфинанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 7 сарын
18 өдрийн 03/2022 тоот тогтоолын хавсралт № 4



ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү бодлогын зорилт нь “Жэтфинанс ББСБ” ХХК /цаашид “ББСБ” гэх/-ийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулах, удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүйгээр суларснаас үүдэн ББСБ-ын хэвийн үйл ажиллагааг хангахын тулд залгамж халааг бэлтгэн төлөвлөхөд оршино.

1.2. Энэхүү бодлогоор Гүйцэтгэх удирдлага, түүний багийн гишүүний залгамж халааг төлөвлөнө.

ХОЁР. ЗАЛГАМЖ ХАЛААГ БЭЛТГЭХ

2.1. Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны төлөвлөгөө

2.1.1. Төлөөлөн Удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/ нь дотоод эх үүсвэрээс гүйцэтгэх удирдлагын албан тушаалд тохирох хүнийг олж тодорхойлно.

2.1.2. ТУЗ нь гүйцэтгэх удирдлагын албан тушаалд шинээр буюу улираан нэр дэвшүүлэхээр эсхүл томилохоор төлөвлөж буй хүн тус бүрийн тухайн албан тушаалд тохирох эсэхийг боловсрол, туршлага, гаргасан амжилтыг нь нягтлан шалгасны үндсэн дээр тодорхойлно.

2.1.3. Гүйцэтгэх удирдлагын албан тушаалд ажиллах хүнийг шинээр болон улираан нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо /цаашид “Хороо” гэх/-ны саналыг үндэслэн ТУЗ шийдвэр гаргах ба компанийн дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ. Ийнхүү нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөхөд Компанийн тухай хууль болон компанид хамаарах бусад хууль тогтоомж, дүрэм журмын холбогдох зүйл заалтуудыг мөрдлөг болгоно.

2.2. Гүйцэтгэх удирдлагын багийн залгамж халааны төлөвлөгөө

2.2.1. Хороо нь Гүйцэтгэх захирлын хамтаар Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс тухайн жилд тэтгэвэрт гарах эсхүл чөлөөлөгдөх хүсэлтэй хүн байгаа эсэхийг тодорхой давтамжтайгаар нягталж, хяналт тавина. Бизнесийн хэрэгцээ шаардлага болон газар, нэгжийг өргөтгөхтэй холбогдуулан шинээр гарч болзошгүй орон тоог Хороо болон Гүйцэтгэх захирлын санал болгосноор, ТУЗ шийдвэрлэнэ. Хорооноос ББСБ-ын цаашдын өсөлт, хөгжилд тохирох нэр дэвшигчид бэлэн байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгнө.

2.2.2. Гүйцэтгэх удирдлагын баг доторх чөлөөтэй орон тоо, томилгооны асуудлыг байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, зорилго, зорилттой уялдуулна.

2.2.3. Гүйцэтгэх захирал нь албан тушаал дэвшин ажиллах чадварлаг ажилтнуудыг тодорхойлох ба санал болгох, ур чадварыг нь хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, хяналт тавих ба үнэлж дүгнэх, тухайн ажилтнуудад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлон ажиллах зэргийг хариуцна.

2.2.4. Гүйцэтгэх захирал нь ББСБ-ын тодорхой чиг үүргийг удирдан ажиллах чадварлаг ажилтнуудыг олж тогтоох, хөгжүүлэхэд чиглэсэн дотоод журам, хөтөлбөр боловсруулна.

ГУРАВ. ГЭНЭТИЙН ТОХИОЛДОЛД АВАХ АРГА ХЭМЖЭЭ

3.1. Удирдах захирал нас барсан, өөр бусад гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдсөн тохиолдолд Хорооны санал болгосноор ТУЗ яаралтай хуралдаж, орлох этгээдийг тодорхойлон, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн томилгоог албажуулна.

3.2. Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтан урт хугацаанд өвчтэй, чөлөөтэй байх үед түүний ажил үүргийг гүйцэтгэн орлох этгээдийг Гүйцэтгэх захирал томилно. Хороо нь тус ажилтныг тухайн ажил үүргийг гүйцэтгэх чадваргүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай Гүйцэтгэх захиралтай зөвшилцөн, томилгоог өөрчилж болно.

ДӨРӨВ. ХЯНАЛТ, САЙЖРУУЛАЛТ

4.1. Энэхүү бодлогын хэрэгжилтэд Хороо хяналт тавьж ажиллах ба ТУЗ-өөс энэхүү Бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, түүнийг дагалдах залгамж халааны төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжиж буй эсэхийг хянах зорилгоор үнэлэлт дүгнэлт өгнө.

4.2. ТУЗ нь тус Бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбоотойгоор холбогдох этгээдээс тодруулга авах, аливаа асуудал гарвал засаж залруулах бүрэн эрхтэй байна.

4.3. Холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагаар тус Бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах тохиолдолд Хорооны санал болгосноор ТУЗ

батална.

ТАВ. БУСАД

5.1. Энэхүү бодлогоор зохицуулагдах боломжгүй аливаа харилцааг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын эрх зүйн баримт бичгийг баримтлан шийдвэрлэнэ.

“ЖЭТФИНАНС ББСБ” ХХК

